

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.2-т заасан шууд худалдан авах, мөн хуулийн 34.1-д заасан харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолоор баталсан төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөн ажиллахыг бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.

3.Энэ тогтоолыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж дагаж мөрдөнө.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН

Төсөвт өртгийн дээд хязгаар

№	Ангилал	Бараа (сая.төг)	Ажил (сая.төг)	Үйлчилгээ (сая.төг)
1.	Шууд худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаар	20.0	20.0	20.0
2.	Харьцуулалтын аргаар худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаар	100.0	150.0	100.0

---oOo---